**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/218/НА- СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5
3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 12
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 15
4.1 Ерөнхий зүйл ........ 15
4.2 Материаллаг байдал ........ 15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 17
5.1. Төлбөрийн акт ........ 17
5.2. Албан шаардлага ........ 18
5.3. Зөвлөмж ........ 20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 21


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Орон нутгийн өмчийн газар |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/63

танай____________-ны № _____________ -т

БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА М.ЖАВЗАНСҮРЭН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн;
- Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 45,000.0 мянган төгрөгийн 2019 онд үндсэн хөрөнгөд бүртгэсэн хадлангийн трактор биетээр байхгүй;
- Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн тооллогын комисс бараа материалыг тоолоогүй;
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг 2023 онд давтан гаргасан байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх “Тооллогын комисс дараах үүрэгтэй: эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтууд болон

5020238

УСНББОУС 17 болон Оршин байх, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 70106 (Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдах) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс баталсан санхүүжилтээс 992,343.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, өөрийн орлогоор 1,000.0 мянган төгрөгийг оруулан, гүйцэтгэлээр 985,987.0 мянган төгрөгийг зарцуулж, зардлын хэмнэлтийн 7,591.1 мянган төгрөгийг оны эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлд тавих хяналт, дотоод хяналт сул, анхан шатны баримтын бүрдүүлэлт, нярвын бараа материалын тайлангийн үнэн зөв байдал хангалтгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 96.4 хувиар тайлагнасан байна.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **253,399,120.91** | **175,045,044.96** |
| **33** | **АВЛАГА** | **3,207,142.55** | **123,737.90** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,090,742.55 | 98,737.90 |
| **33500** | **Бусад авлага** | **116,400.00** | **25,000.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 116,400.00 | 25,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **100,191,978.36** | **174,921,307.06** |
| **35100** | **Түүхий эд материал** | **4,897,230.00** | **4,897,230.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,897,230.00 | 4,897,230.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **95,294,748.36** | **162,422,747.06** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,687,120.00 | 2,312,120.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 66,158,798.36 | 93,631,002.25 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 6,005,000.00 | 0 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,568,330.00 | 2,721,624.81 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,005,500.00 | 1,005,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 345,000.00 | 0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 18,525,000.00 | 62,752,500.00 |
| 35600 | Мал амьтад | 0 | 7,601,330.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | **150,000,000.00** | **0** |
| 36600 | Бусад нөөц | 150,000,000.00 | 0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,736,589,999.49** | **1,897,310,871.83** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,736,589,999.49** | **1,897,310,871.83** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,607,721,999.49** | **1,768,804,871.83** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,413,871,922.00 | 1,756,426,961.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -327,767,232.59 | -398,461,641.74 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 398,963,800.00 | 321,753,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -163,094,300.25 | -161,027,099.75 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 321,215,309.00 | 301,232,378.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -201,843,263.30 | -214,459,862.22 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 56,374,211.13 | 52,714,304.13 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -35,792,084.50 | -36,554,134.05 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 240,876,355.00 | 236,736,355.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -100,882,717.00 | -95,356,188.54 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 5,800,000.00 | 5,800,000.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **128,868,000.00** | **128,506,000.00** |
| 39301 | Програм хангамж | 780,000.00 | 780,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -390,000.00 | -546,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 128,478,000.00 | 128,272,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,989,989,120.40** | **2,072,355,916.79** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **360,000.00** | **542,833.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **360,000.00** | **542,833.00** |
| **41300** | **Өглөг** | **360,000.00** | **542,833.00** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0 | 542,833.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 360,000.00 | 0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,989,629,120.40** | **2,071,813,083.79** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,989,629,120.40** | **2,071,813,083.79** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 525,709,281.22 | 525,709,281.22 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 525,709,281.22 | 525,709,281.22 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,164,073,569.43** | **1,273,966,732.82** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 920,995,863.26 | 1,191,782,769.43 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 243,077,706.17 | 82,183,963.39 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 299,846,269.75 | 272,137,069.75 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,989,989,120.40** | **2,072,355,916.79** |



005 ... ЗАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **984,341,115.25** | **1,171,131,050.10** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **145,900,488.25** | **145,318,359.10** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **145,900,488.25** | **145,318,359.10** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **142,250,855.00** | **1,000,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 620,000.00 | 1,000,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 141,630,855.00 | 0 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 3,500,000.00 | 55,832,110.10 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 149,633.25 | 88,486,249.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **838,440,627.00** | **1,025,812,691.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **71,024,427.00** | **33,469,691.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 50,789,600.00 | 9,629,445.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,234,827.00 | 23,840,246.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **767,416,200.00** | **992,343,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 767,416,200.00 | 992,343,000.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **735,611,904.19** | **1,031,192,530.85** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **735,611,904.19** | **1,031,192,530.85** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **696,223,083.44** | **1,019,079,633.29** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **270,365,311.23** | **459,176,396.40** |
| 210101 | Үндсэн цалин | 270,365,311.23 | 459,176,396.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **33,763,400.23** | **57,972,882.23** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,039,362.05 | 39,222,706.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,869,256.82 | 5,042,256.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,172,396.40 | 3,676,429.88 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 557,804.45 | 911,953.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,124,580.51 | 9,119,535.66 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **45,852,425.23** | **54,774,949.25** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,016,761.23 | 12,393,079.25 |
| 210302 | Түлш, халаалт | 36,835,664.00 | 42,381,870.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **64,417,598.54** | **81,692,300.01** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,695,320.00 | 7,941,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,101,578.54 | 32,733,185.19 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 509,800.00 | 976,465.21 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,040,000.00 | 30,620,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,070,900.00 | 9,420,849.61 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **0** | **14,029,700.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0 | 6,005,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0 | 1,280,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 0 | 6,744,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,109,000.00** | **11,314,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,109,000.00 | 11,314,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **66,412,877.00** | **30,601,019.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 59,969,190.00 | 17,838,692.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 713,925.00 | 969,075.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 352,868.00 | 1,081,324.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 741,934.00 | 319,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,710,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 570,960.00 | 6,182,928.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **208,302,471.21** | **309,518,386.40** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,950,889.00 | 133,921,655.50 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 174,351,582.21 | 175,596,730.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **39,388,820.75** | **12,112,897.56** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **13,652,900.00** | **500,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0 | 500,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,552,900.00 | 0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,100,000.00 | 0 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **25,735,920.75** | **11,612,897.56** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,373,943.75 | 7,355,986.56 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,361,977.00 | 4,256,911.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **248,729,211.06** | **139,938,519.25** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **5,651,504.89** | **57,754,555.86** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 5,651,504.89 | 57,754,555.86 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **243,077,706.17** | **82,183,963.39** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **839,060,627.00** | **1,026,812,691.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **620,000.00** | **1,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **620,000.00** | **1,000,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **620,000.00** | **1,000,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 620,000.00 | 1,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **838,440,627.00** | **1,025,812,691.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **71,024,427.00** | **33,469,691.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 50,789,600.00 | 9,629,445.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,234,827.00 | 23,840,246.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **767,416,200.00** | **992,343,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 767,416,200.00 | 992,343,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **785,151,627.00** | **838,572,642.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **785,151,627.00** | **838,572,642.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **745,762,806.25** | **826,159,744.44** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **275,475,907.51** | **451,709,440.98** |
| 210101 | Үндсэн цалин | 219,636,010.55 | 289,148,623.09 |
| 210102 | Нэмэгдэл | 0 | 114,342,957.50 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0 | 28,023,951.31 |
| 210104 | Урамшуулал | 0 | 20,193,909.08 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 55,839,896.96 | 0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **31,775,946.51** | **62,405,000.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,734,400.00 | 42,593,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,520,900.00 | 4,953,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,936,700.00 | 3,932,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 555,300.00 | 1,020,100.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,028,646.51 | 9,906,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **64,553,395.23** | **54,774,949.25** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,016,761.23 | 12,393,079.25 |
| 210302 | Түлш, халаалт | 55,536,634.00 | 42,381,870.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **48,202,920.00** | **76,760,455.21** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,851,120.00 | 4,435,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,076,000.00 | 33,072,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 834,500.00 | 1,388,565.21 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 9,980,000.00 | 30,020,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,461,300.00 | 7,844,690.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **0** | **7,645,900.00** |
| 210604 | Урсгал засвар | 0 | 7,645,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **6,549,000.00** | **11,674,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,549,000.00 | 11,674,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **71,901,637.00** | **42,857,299.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 65,457,950.00 | 30,386,972.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 757,793.00 | 969,075.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 794,934.00 | 1,096,024.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 256,000.00 | 319,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,418,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 570,960.00 | 6,168,228.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **247,304,000.00** | **118,332,700.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 247,304,000.00 | 118,332,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **39,388,820.75** | **12,412,897.56** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **13,652,900.00** | **800,000.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,552,900.00 | 0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,100,000.00 | 800,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **25,735,920.75** | **11,612,897.56** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,373,943.75 | 7,355,986.56 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,361,977.00 | 4,256,911.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **53,909,000.00** | **188,240,049.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **53,909,000.00** | **188,240,049.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **53,909,000.00** | **188,240,049.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **53,909,000.00** | **188,240,049.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 53,909,000.00 | 188,240,049.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-53,909,000.00** | **-188,240,049.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **525,709,281.22** | **301,574,674.62** | **919,267,458.39** | **1,746,551,414.23** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0** | **0** | **1,728,404.87** | **1,728,404.87** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **525,709,281.22** | **301,574,674.62** | **920,995,863.26** | **1,748,279,819.10** |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0** | **-1,728,404.87** | **0** | **-1,728,404.87** |
| **5** | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **0** | **0** | **0** | **0** |
| **6** | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | **0** | **0** | **0** | **0** |
| **7** | **Өмчид гарсан өөрчлөлт** | **0** | **0** | **0** | **0** |
| **8** | **Зарласан ногдол ашиг** | **0** | **0** | **0** | **0** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0** | **0** | **243,077,706.17** | **243,077,706.17** |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **525,709,281.22** | **299,846,269.75** | **1,164,073,569.43** | **1,989,629,120.40** |
| **11** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **525,709,281.22** | **299,846,269.75** | **1,164,073,569.43** | **1,989,629,120.40** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 27,709,200.00 | 27,709,200.00 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **525,709,281.22** | **299,846,269.75** | **1,191,782,769.43** | **2,017,338,320.40** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | -27,709,200.00 | 0 | -27,709,200.00 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 | 0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 82,183,963.39 | 82,183,963.39 |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **525,709,281.22** | **272,137,069.75** | **1,273,966,732.82** | **2,071,813,083.79** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **993,578,100.00** | **985,987,013.44** | **7,591,086.56** | **99.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **993,578,100.00** | **985,987,013.44** | **7,591,086.56** | **99.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **992,278,100.00** | **985,187,013.44** | **7,091,086.56** | **99.29** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **451,710,000.00** | **451,709,440.98** | **559.02** | **100.00** |
| 210101 | Үндсэн цалин | 287,525,500.00 | 289,148,623.09 | **-1,623,123.09** | **100.56** |
| 210102 | Нэмэгдэл | 114,812,800.00 | 114,342,957.50 | **469,842.50** | **99.59** |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,448,000.00 | 28,023,951.31 | **-5,575,951.31** | **124.84** |
| 210104 | Урамшуулал | 26,923,700.00 | 20,193,909.08 | **6,729,790.92** | **75.00** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **62,405,000.00** | **62,405,000.00** | **0.00** | **100.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,593,000.00 | 42,593,000.00 | **0.00** | **100.00** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,953,000.00 | 4,953,000.00 | **0.00** | **100.00** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,962,400.00 | 3,932,900.00 | **29,500.00** | **99.26** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 990,600.00 | 1,020,100.00 | **-29,500.00** | **102.98** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,906,000.00 | 9,906,000.00 | **0.00** | **100.00** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **56,340,800.00** | **54,774,949.25** | **1,565,850.75** | **97.22** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,000,000.00 | 12,393,079.25 | **1,606,920.75** | **88.52** |
| 210302 | Түлш, халаалт | 42,340,800.00 | 42,381,870.00 | **-41,070.00** | **100.10** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **77,906,400.00** | **77,120,455.21** | **785,944.79** | **98.99** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,570,000.00 | 4,435,200.00 | **134,800.00** | **97.05** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,200,000.00 | 33,072,000.00 | **128,000.00** | **99.61** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,226,400.00 | 1,388,565.21 | **-162,165.21** | **113.22** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 30,560,000.00 | 30,020,000.00 | **540,000.00** | **98.23** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,350,000.00 | 8,204,690.00 | **145,310.00** | **98.26** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **27,866,500.00** | **27,245,900.00** | **620,600.00** | **97.77** |
| 210604 | Урсгал засвар | 27,866,500.00 | 27,245,900.00 | **620,600.00** | **97.77** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **11,750,200.00** | **11,674,000.00** | **76,200.00** | **99.35** |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,750,200.00 | 11,674,000.00 | **76,200.00** | **99.35** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,164,000.00** | **13,644,519.00** | **519,481.00** | **96.33** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,300,000.00 | 1,174,192.00 | **125,808.00** | **90.32** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 | **0.00** | **100.00** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,000,000.00 | 969,075.00 | **30,925.00** | **96.91** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,150,000.00 | 1,096,024.00 | **53,976.00** | **95.31** |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 450,000.00 | 319,000.00 | **131,000.00** | **70.89** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,418,000.00 | **146,000.00** | **95.90** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 6,200,000.00 | 6,168,228.00 | **31,772.00** | **99.49** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **290,135,200.00** | **286,612,749.00** | **3,522,451.00** | **98.79** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 290,135,200.00 | 286,612,749.00 | **3,522,451.00** | **98.79** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,300,000.00** | **800,000.00** | **500,000.00** | **61.54** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,300,000.00** | **800,000.00** | **500,000.00** | **61.54** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,300,000.00 | 800,000.00 | **500,000.00** | **61.54** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **993,578,100.00** | **985,987,013.44** | **7,591,086.56** | **99.24** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **992,578,100.00** | **984,987,013.44** | **7,591,086.56** | **99.24** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 992,578,100.00 | 984,987,013.44 | **7,591,086.56** | **99.24** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **1,000,000.00** | **1,000,000.00** | **0.00** | **100.00** |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,000,000.00 | **0.00** | **100.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **0.00** | **100.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | **0.00** | **100.00** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **22** | **22** | **0.00** | **100.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 7 | 7 | **0.00** | **100.00** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 | **0.00** | **100.00** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4 | 4 | **0.00** | **100.00** |
| 620004 | Гэрээт ажилтан | 2 | 2 | **0.00** | **100.00** |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **22** | **22** | **0.00** | **100.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 9 | **0.00** | **100.00** |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5 | 5 | **0.00** | **100.00** |
| 650010 | Гэрээт ажилтан | 2 | 2 | **0.00** | **100.00** |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 6 | 6 | **0.00** | **100.00** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **33,469,691** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **33,469,691** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 33,469,691 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 33,469,691 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 33,469,691 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 33,469,691 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 33,469,691 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 33,469,691 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ нь "Сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүргийг хэрэгжүүлэх, хариуцлагатай хамт олныг бүрдүүлж, чанартай, хүртээмжтэй төрийн үйлчилгээг иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөн буй орчинд уян хатан зохицож чаддаг бөгөөд идэвхтэй, санаачилгатай, манлайлагч менежер бүхий цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн, бусдад үлгэрлэхүйц жишиг байгууллага байх" эрхэм зорилготой тус байгууллага нь үндсэн ажилтан 20, гэрээт ажилтан 2 нийт 22 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга М.Жавзансүрэн, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Алимаа нар зурж, нярваар П.Батцэцэг ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82,366.8 мянган төгрөгөөр буюу 104.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | - | 0 |
| Авлага | 3,207.1 | 123.7 | (3,083.4) |
| Бараа материал | 250,192.0 | 174,921.3 | (75,270.7) |
| Үндсэн хөрөнгө | 2,566,359.6 | 2,803,715.8 | 237,356.2 |
| Хуримтлагдсан элэгдэл | (829,769.6) | (906,404.9) | (76,635.3) |
| **Нийт хөрөнгө** | **1,989,989.1** | **2,072,355.9** | **82,366.8** |
| Өр төлбөр | 360.0 | 542.8 | 182.8 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,989,629.1 | 2,071,813.1 | 82,183.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,989,989.1** | **2,072,355.9** | **82,366.8** |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2022 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Оны эхний авлагын 3,207.1 мянган төгрөгийн авлагаас хувь хүний орлогын албан татварын 2,758.9 мянга, цалингийн 331.7 мянга, бусад байгууллагаас авах авлагын 116.4 мянган төгрөгийг бүрэн барагдуулан, оны эцэст 123.7 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

Бараа материал оны эхний үлдэгдлээс 75,270.7 мянган төгрөгөөр буурч 174,921.3 мянган төгрөг болсон нь өмнөх онд дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй 150,000.0 мянган төгрөгийн үнэлгээтэй Байгалийн музей болон орон нутаг судлах танхимын барилгыг дуусган үндсэн хөрөнгөд бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө өмнөх оноос 238,923.7 мянган төгрөгөөр өсөж 2,805,283.3 мянган төгрөг болсон нь төсвийн хөрөнгөөр 188,240.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, эрх бүхий байгууллагуудын шийдвэрээр 227,741.7



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж, 177,058.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Оны эхний 360.0 мянган төгрөгийн томилолтын өглөгийг барагдуулж, оны эцэст 542.8 мянган төгрөгийн үйлдвэрчний эвлэлийн өглөгтэй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 82,183.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,071,813.1 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 585,533.1 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 338,218.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2023 оны төсвийг 923,751.8 мянган төгрөгөөр баталсан нь санхүүжилтийг орон нутгаас 100 хувь санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Оны эхэнд баталсан анхны төсвийг сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн тогтоолоор 69,826.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр нийт төсөв 993,578.1 мянган төгрөг болсон ба 2023 оны 11 дүгээр сард зардал хооронд төсөвт зохицуулалт хийж, 992,578.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгож, 1,000.0 мянган төгрөгийн өөрийн орлого оруулахаар төлөвлөжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106 (Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдах) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс баталсан санхүүжилтээс 992,343.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, өөрийн орлогоор 1,000.0 мянган төгрөгийг оруулан, гүйцэтгэлээр 985,987.0 мянган төгрөгийг зарцуулж, зардлын хэмнэлтийн 7,591.1 мянган төгрөгийг оны эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Хөтөлбөр | Арга хэмжээ | Төсөв | Гүйцэтгэл | зөрүү |
|---|---|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны зардал | 70106 | 80101 | 591,188.7 | 588,050.7 | 3,138.0 |
| Баг, хорооны ҮАЗардал | 70106 | 80106 | 97,794.2 | 97,103.5 | 690.7 |
| Ажил олгогчоос олгох тэтгэмж | 70106 | 80806 | 1,000.0 | 800.0 | 200.0 |
| Орон нутгийн нөөц хөрөнгө | 70106 | 81102 | 85,000.0 | 81,512.7 | 3,487.3 |
| Байгаль орчныг хамгаалах, нөхөн | 70106 | 81701 | 188,135.2 | 188,100.0 | 35.2 |
| Хур хог хаягдал, орчны бохирдол | 70106 | 82212 | 13,460.0 | 13,420.0 | 40.0 |
| Гамшгаас сэргийлэх сургалт | 70106 | 82310 | 17,000.0 | 17,000.0 | - |
| Нийт дүн | | | 993,578.1 | 985,987.0 | 7,591.1 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ-ын төсвийн хэлбэлзэл*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар Өмнөговь аймгийн Засаг даргын А/264 дүгээр захирамжаар Баян-Овоо сумын нутагт отроор явж байгаа малчдыг эргэх зардалд 5,000.0 мянга, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 949.4 мянга, хяналт шинжилгээ үнэлгээний тэргүүн байрын шагнал 6,480.0 мянга, өвсний үнийн 5,962.5 мянга, аж ахуйн нэгжүүдээс барьцааны хөрөнгийн 4,373.0 мянга гэх мэт нийт 33,469.7 мянган төгрөгийн орлого оржээ.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орсон санхүүжилтээс 29,212.8 мянган төгрөгийн зарцуулан, оны эцэст орон нутгийн орлогод 4,256.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гаргасан холбогдох шийдвэрийн дагуу сэлбэг хэрэгслийг худалдан авч, суудлын автомашины хувийн хэргийн хөтлөлтийг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 923,800.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,238.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,466.6 мянган төгрөгөөр тогтоосон.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй, хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал" гэснийг зөрчсөн тул аудитаар төлбөрийн акт тогтоов.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 199,498.5 мянган төгрөгийн орлогын 5, 32,092.1 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, 130,827.7 мянган төгрөгийн хөрөнгө захиран зарцуулах 21 тушаал, шийдвэр, байгууллагын даргын тайланд онд байгуулсан 15 гэрээг байршуулаагүй орхигдуулсан зөрчил илэрсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрсэнд Төрийн аудитын байгууллагаас албан шаардлага өгсөн байхад 2023 онд зөрчлийг давтан гаргасан тул байгууллагын нягтлан бодогчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, 572.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 65,945.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлэн, 620.0 мянган



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төгрөгийн 2 зөрчилд менежментийн захидлаар зөвлөмж хүргүүлсэн байна. Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлөөс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг тухай бүр байршуулаагүй зөрчил дахин давтагдан илэрлээ.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | **1** | **572.8** | **1** | **572.8** | **100** |
| Албан шаардлага | 3 | 65,945.0 | 3 | 65,945.0 | 100 |
| Зөвлөмж | 2 | 620.0 | 2 | 620.0 | 100 |
| **Нийт дүн** | **6** | **67,137.8** | **6** | **67,137.8** | **100** |

*Эх сурвалж: СТА-ын FAS систем, Баян-Овоо сумын ЗДТГ-ын 2023.05.26-ны өдрийн 114 дүгээр албан бичиг*

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2019 онд ашиглалтад орсон 45,000.0 мянган төгрөгийн хадлангийн трактор Баян-Өлгий аймагт байгаа асуудлыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 181,162.7 мянган төгрөгийн 10 зөрчил[1] илэрснээс 2.449.0 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 176,921.3 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах 5 албан шаардлага өгч, 2,792.4 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 1 зөвлөмжийг менежментийн захидлаар өглөө.

### 5.1. Төлбөрийн акт

1. Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2023 онд сумын Засаг даргаар төсөвт ороогүй төлбөрийг оруулах төлбөрийн акт тогтоосон байхад төлбөрийн актын 1,400.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд 435.0 мянган төгрөгийн нэгжний үнийг 29 албан хаагчид олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Бараа материалын тайлангийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад 33.9 мянган төгрөгийн 2 боодол няцалсан будаа, 380.0 мянган төгрөгийн 19 ширхэг улаан хивгийг анхан шатны баримтгүй зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэснийг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Байгууллагын нярваар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

4. Байгууллагын нягтлан бодогч нэр бүхий албан хаагчдын 11 дүгээр сарын цалинг нийгмийн даатгалын мэдээнд 200.1 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө" гэснийг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Албан хаагчдын 2023 оны 11 дүгээр сарын цалинг нийгмийн даатгалын мэдээнд залруулан, холбогдох шимтгэлийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.2. Албан шаардлага**

1. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор бараа материалыг тоолсон эсэхийг аудитаар нотолж чадаагүй, агуулахын бүртгэлээр тоолсон гэх боловч тооллогын комиссын гишүүдийн гарын үсэг байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх "Тооллогын комисс дараахь үүрэгтэй: эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэснийг зөрчсөн, Оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн:Санхүүгийн тайланд бүртгэлтэй бараа материалыг нүд үзэн тоолж, нотлох баримтыг санхүүгийн баримтад хавсаргах албан шаардлагыг хүргүүлэв.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2. Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн газрын судалгаатай санхүүгийн тайлан дахь газартай тулган шалгахад сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/101 дүгээр захирамжаар олгосон 1537 м2 талбай бүхий газрыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд биет бус хөрөнгийг бүртгэж зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

3. Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 32,092.1 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, 130,827.7 мянган төгрөгийн хөрөнгө захиран зарцуулах 21 тушаал, шийдвэр, байгууллагын даргын тайланд онд байгуулсан 15 гэрээг байршуулаагүй орхигдуулсан байгаа бөгөөд өмнөх жилийн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэснийг үндэслэн байгууллагын нягтлан бодогч Л.Алимаад сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг байгууллагын төсвийн захирагчид хүргүүлэв.

4. Байгууллагын нярвын бэлтгэсэн бараа материалын тайлангууд ерөнхий дэвтрийн дүнгээс зөрүүтэй, урсгал засварын бараа материалын тайланг гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэнтэй нийцэхгүй.

Шийдвэрлэсэн нь:Бараа материалын тайланг анхан шатны баримтад үндэслэн гаргах албан шаардлагыг хүргүүлэв.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

5. Баян-Овоо сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Б/10 дугаар захирамжаар Өвөр монголын өөртөө засах оронд туршлага судлах зардалд олгосон 2,000.0 мянган төгрөгийн анхан шатны баримт байхгүй байгаа тул баримтыг санхүүгийн баримтад хавсаргах албан шаардлагыг хүргүүлэв.

### 5.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын өмч хамгаалах зөвлөл автомашины сэлбэгийг олгох талаар хэлэлцээгүй, байгууллагын дарга хөрөнгө захиран зарцуулах шийдвэрийг гаргаагүй, автомашины хувийн хэргийг хөтлөөгүй байна.

Энэ нь Засгийн Газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.1.1-т “Байгууллага нь үндсэн үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр тус тусад нь тушаал, захирамж гаргана: байгууллагын үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөв, зардал батлах, хөрөнгө зарцуулах зэрэг асуудалд холбогдох тушаал, захирамж хамаарна”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т " Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөл, байгууллагын даргын шийдвэрийг үндэслэн төсвийн хөрөнгийг зарцуулж, автомашины хувийн хэргийг тухай бүрд хөтөлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох албан хаагчдад талархал илэрхийлье.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Үүнээс: Албан шаардлага | | Үүнээс: Зөвлөмж | | Үүнээс: Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| Төрийн аудитын газраас тогтоосон төлбөрийг актыг сумын Засаг даргаар төлүүлэхээр байхад төсвийн хөрөнгөөс төлсөн байна. | 1 | 1,400.0 | 1 | 1,400.0 | | | | | | |
| Бараа материалын тайлангийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад 33.9 мянган төгрөгийн 2 боодол няцалсан будаа, 380.0 мянган төгрөгийн 19 ширхэг улаан хивгийг анхан шатны баримтгүй зарлагадсан байна. | 1 | 413.9 | 1 | 413.9 | | | | | | |
| Байгууллагын нягтлан бодогч нэр бүхий ажилтнуудын 11 дүгээр сарын цалинг нийгмийн даатгалын мэдээнд 200.1 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна. | 1 | 200.1 | 1 | 200.1 | | | | | | |
| Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор бараа материалыг тоолсон эсэхийг аудитаар нотолж чадаагүй, агуулахын бүртгэлээр тоолсон гэх боловч тооллогын комиссын гишүүдийн гарын үсэг байхгүй байна. | 1 | 174,921.3 | | | 1 | 174,921.3 | | | | |
| Баянхонгор аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн газрын судалгаатай санхүүгийн тайлан дахь газартай тулган шалгахад сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/101 дүгээр захирамжаар олгосон 1537 м2 талбай бүхий газрыг санхүүгийн тайланд тусгаагүй байна. | 1 | - | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Байгууллагын нярвын бэлтгэсэн бараа материалын тайлангууд ерөнхий дэвтрийн дүнгээс зөрүүтэй, урсгал засварын бараа материалын тайланг гаргаагүй байгаа нь УСНББОУС-ын 17 заалтыг зөрчсөн байна. | 1 | - | | | 1 | - | | | | |
| Баян-Овоо сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Б/10 дугаар захирамжаар Өвөрмонголын өөртөө засах оронд туршлага судлах зардалд олгосон 2,000.0 мянган төгрөгийн анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй байна. | 1 | 2,000.0 | | | 1 | 2,000.0 | | | | |
| Байгууллагын өмч хамгаалах зөвлөл автомашины сэлбэгийг олгох талаар хэлэлцээгүй, байгууллагын дарга хөрөнгө захиран зарцуулах шийдвэрийг гаргаагүй, автомашины хувийн хэргийг хөтлөөгүй байна. | 1 | 2,792.4 | | | | | 1 | 2,792.4 | | |
| Дүн | 9 | 181,727.7 | 3 | 2,014.0 | 4 | 176,921.3 | 1 | 2,792.4 | 1 | 1 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 32,092.1 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, 130,827.7 мянган төгрөгийн хөрөнгө захиран зарцуулах 21 тушаал, шийдвэр, байгууллагын даргын тайланд онд байгуулсан 15 гэрээг байршуулаагүй орхигдуулсан байгаа бөгөөд өмнөх жилийн зөрчлийг давтан гаргасан байна. | 1 | - | | | 1 | - | | |
| Дүн | 1 | - | 0 | 0 | 1 | - | 0 | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /Төрийн хэмнэлтийн тухай хууль/ | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэлгүй, тайлант онд 435.0 мянган төгрөгийн нэгжний үнийг 29 албан хаагчид олгосон байна. | 1 | 435.0 | 1 | 435.0 | | | | |
| Дүн | 1 | 435.0 | 1 | 435.0 | 0 | 0 | 0 | 0 |
| Нийт дүн | 2 | 435.0 | 1 | 435.0 | 1 | - | 0 | 0 |

---oOo---

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 99/1/А0560228/БНА Нөмгөн
2024/218/НА- СТА -ТШЗ

# ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2023 онд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитаар тогтоосон төлбөрийн актыг сумын Засаг даргаар төлүүлэхээр байхад төлбөрийн актын 1,400,000 (Нэг сая дөрвөн зуун мянган) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас төлсөн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан төсвийн хөрөнгийг Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга, М.Жавзансүрэн, нягтлан бодогч Л.Алимаа нараар төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төлбөрийг төвлөрүүлэх.
2. Аудитаар тогтоосон 1,400,000 (Нэг сая дөрвөн зуун мянган) төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 06 дугаар сарын 28-ны

5050320

дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Жавзансүрэн, нягтлан бодогч Л.Алимаа нарт даалгав[2],[3].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР Б.ДОЛЖМАА

6417142844
BЮAO27..8037423

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[4] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 100/2/A0560238/БНА 2024/218/НА-ЧТА-ТШБ Нөмгөн

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 435,000 (Дөрвөн зуун гучин таван мянган) төгрөгийн нэгжний үнийг байгууллагын 29 албан хаагчид олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан төсвийн хөрөнгийг Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдаар төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төлбөрийг төвлөрүүлэх.
2. Аудитаар тогтоосон 435,000 (Дөрвөн зуун гучин таван мянган) төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 06 дугаар сарын

5050325

28-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Жавзансүрэн, нягтлан бодогч Л.Алимаа нарт даалгав[2],[3].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР Б.ДОЛЖМАА

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[4] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 101/3/А0560218/БНА 2024/218/НА-СТА-ТИЗ Номгон

# ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын бараа материалын тайлангийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад 33,900 (Гучин гурван мянга есөн зуун) төгрөгийн 2 боодол няцалсан будаа, 380,000 (Гурван зуун наян) төгрөгийн 19 ширхэг улаан хивгийг анхан шатны баримтгүй зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүй олгосон 413,300 (Дөрвөн зуун арван гурван мянга гурван зуун) төгрөгийн бараа материалын үнийг Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Жавзансүрэн, нягтлан бодогч Л.Алимаа төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төлбөрийг төвлөрүүлэх.

5050326

2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 06 дугаар сарын 28-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Жавзансүрэн, нягтлан бодогч Л.Алимаа нарт даалгав[2],[3].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР Б.ДОЛЖМАА

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[4] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 108/4/A0560288/БНА 2024/218/НА-СТА-TLUS Номгон

## ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч албан хаагч М.Ганбаатарын 2023 оны 11 дүгээр сарын цалинг нийгмийн даатгалын мэдээнд 200,163 (Хоёр зуун мянга нэг зуун жаран гурав) төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан хаагчийн цалинг нийгмийн даатгалын мэдээнд залруулан, холбогдох нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх
2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 06 дугаар сарын 28-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын

5050301

газарт[1] ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын  дарга М.Жавзансүрэн, нягтлан бодогч Л.Алимаа нарт даалгав[2], [3].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР Б.ДОЛЖМАА

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[4] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр | Дугаар 186/1/A0560238/BOA 2024/218/HA-CTA ТШ3 | Номгон

# ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор бараа материалыг тоолсон эсэхийг аудитаар нотолж чадаагүй, агуулахын бүртгэлээр тоолсон гэх боловч тооллогын комиссын гишүүдийн гарын үсэг байхгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй: бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх", 72 дугаар зүйлийн 72.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна", 72.4 дэх "Тооллогын комисс дараах үүрэгтэй: комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4

5040562
D/2024-ASH

дугээр зүйлийн 4.2.1.2 дахь "Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийг нүд үзэн тоолж, баримтжуулан баталгаажуулах, албан хаагчдын эд хөрөнгийн картыг шинэчлэн албажуулж, тооллогын дүнг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн, газрын даргын тушаалаар баталгаажуулан зөрчлийг арилган, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан тухай нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх[1]

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Жавзансүрэн, нягтлан бодогч Л.Алимаа нарт даалгав[2],[3].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР: Б.ДОЛЖМАА

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[4] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 187/2/А0560238/ДНА Номгон
2024/218/НА – СТА – ТПВ3

# ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн газрын судалгаатай санхүүгийн тайлан дахь газартай тулган шалгахад сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/101 дүгээр захирамжаар олгосон 1537 м2 талбай бүхий газрыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040567
D/2024-ASH

1. Байгууллагын санхүүгийн тайланд 1537 м2 талбай бүхий газрыг бүртгэж зөрчлийг арилган, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 04 дугаар сарын 19-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх[1]

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Жавзансүрэн, нягтлан бодогч Л.Алимаа нарт даалгав[2],[3].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР: Б.ДОЛЖМАА

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

[4] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр | Дугаар 188/3/А0508026 8/ВНА 2024/218/НА-СТА-ТИВ | Номгон

# ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын нярвын бэлтгэсэн бараа материалын тайлангууд ерөнхий дэвтрийн дүнгээс зөрүүтэй, нярав урсгал засварын бараа материалын тайланг гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэнтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын тайланг анхан шатны баримтад үндэслэн гарган зөрчлийг арилган, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан тухай нотлох

5040568

баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх[1]

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Жавзансүрэн, нягтлан бодогч Л.Алимаа нарт даалгав[2],[3].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР: Б.ДОЛЖМАА

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[4] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр | Дугаар 189/4/А0580238/ББА 2024/218/НА-СТА-ТШЗ | Номгон

# ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баян-Овоо сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Б/10 дугаар захирамжаар Өвөр монголын өөртөө засах оронд туршлага судлах зардалд олгосон 2,000,000 (Хоёр сая) төгрөгийн анхан шатны баримтыг санхүүгийн тайланд хавсаргаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040573

1. Өвөр монголын өөртөө засах оронд туршлага судлах ажлын санхүүгийн анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргаж зөрчлийг арилган, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан тухай нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх[1]

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Жавзансүрэн, нягтлан бодогч Л.Алимаа нарт даалгав[2],[3].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР: Б.ДОЛЖМАА

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[4] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 25 өдөр Дугаар 247/5/A0560238/БИА Номгон
2024/218/АА-СТА-ТИБ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 32,092,160 (Гучин хоёр сая ерэн хоёр мянга нэг зуун жаран) төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, 130,827,728 (Нэг зуун гучин сая найман зуун хорин долоон мянга долоон зуун хорин найман) төгрөгийн хөрөнгө захиран зарцуулах 21 тушаал, шийдвэр, байгууллагын даргын тайланд онд байгуулсан 15 гэрээг байршуулаагүй орхигдуулсан байгаа бөгөөд тус зөрчил нь өмнөх жилийн аудитаар илэрч байсан, 2023 онд зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1,

5040739

D/2024-ASH

42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10 дахь "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч Л.Алимаад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар[1]-т ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Жавзансүрэнд даалгав[2].

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР: Б.ДОЛЖМАА

---

[1] *Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор хот, 1 дүгээр баг, Нутгийн удирдлагын ордон. Утас: 7044-2584*

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.